

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3.Аудитын тайлан	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал.....	17
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛС ХООРОНДЫН ШУУДАН
ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.ДАВААСҮРЭН ТАНАА

2021.02.25 № 07/597
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлэл Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,724,124.10</u>	<u>40,617,246.07</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	2,432,868.03	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	240,554.40	-
335	Бусад авлага	2,192,313.63	-
3351	Байгууллагаас авах авлага	2,192,313.63	-
35	БАРАА МАТЕРИАЛ	25,291,256.07	40,617,246.07
351	Түүхий эд материал	374,000.00	374,000.00
35110	Тусгай зориулалттай материал	374,000.00	374,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	197,500.00	197,500.00
354	Хангамжийн материал	24,719,756.07	40,045,746.07
35410	Бичиг хэргийн материал	4,912,140.00	6,209,550.00
35420	Аж ахуйн материал	11,436,919.03	19,882,797.03
35430	Сэлбэг хэрэгсэл	3,691,700.00	-
35440	Түлш, шатах тослох материал	501,983.00	1,605,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,177,014.04	12,348,399.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>350,659,209.95</u>	<u>684,658,952.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	350,659,209.95	684,658,952.01
392	Биет хөрөнгө	350,342,959.95	651,669,181.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,196,000.00	109,196,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	54,071,000.00	67,571,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	540,239,542.70	885,936,919.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	251,080,758.57	283,472,927.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,776,791.73	35,292,854.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	27,717,615.91	27,712,664.99
393	Биет бус хөрөнгө	316,250.00	32,989,771.00
39301	Программ хангамж	780,000.00	33,536,021.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	463,750.00	546,250.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>378,383,334.05</u>	<u>725,276,198.08</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>378,383,334.05</u>	<u>725,276,198.08</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	378,383,334.05	725,276,198.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	264,349,638.94	264,349,638.94
51101	Өмч: - төрийн	264,349,638.94	264,349,638.94
512	Хуримтлагдсан үр дүн	114,033,297.11	460,926,161.14
51210	Өмнөх үеийн үр дүн	114,033,297.11	114,033,297.11
51220	Тайлант үеийн үр дүн		346,892,864.03
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398.00	398.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>378,383,334.05</u>	<u>725,276,198.08</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,413,742,320.03	1,941,638,479.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	101,915,420.00	302,099,379.66
120	Нийтлэг татварын бус орлого	101,915,420.00	302,099,379.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	101,915,420.00	302,099,379.66
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	101,915,420.00	302,099,379.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,311,826,900.03	1,639,539,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,310,425,400.00	1,542,439,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,300,425,400.00	1,542,439,100.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	97,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		97,100,000.00
1330	Төсвийн захирагчдаас	1,401,500.03	-
133003	Хөрөнгийн орлого	1,401,500.03	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,357,030,473.80	1,592,905,150.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,357,030,473.80	1,592,905,150.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,339,943,624.18	1,555,823,266.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,099,653,859.11	1,255,147,568.07
210101	Үндсэн цалин	1,050,962,267.35	737,988,831.42
210102	Нэмэгдэл		304,396,951.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,691,591.76	55,969,060.20
210104	Урамшуулал		156,792,725.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,015,242.21	160,441,091.35
210201	Тэтгэврийн даатгал	136,015,242.21	109,892,228.86
210202	Тэтгэмжийн даатгал	-	12,876,615.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	12,557,415.67
210205	Эрүүл мэндийн даатгал	-	25,114,831.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,312,097.50	14,373,166.73
210301	Гэрэл, цахилгаан	912,097.50	1,173,166.73
210304	Байрны түрээс	14,400,000.00	13,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,496,321.00	16,832,557.54
210401	Бичиг хэрэг	10,277,267.51	3,883,320.00
210402	Тээвэр, шатахуун	5,720,821.00	6,151,983.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	215,984.49	1,067,081.54
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,248.00	5,730,173.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,408,316.00	24,503,883.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	908,796.00	1,965,799.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	613,200.00	3,205,600.00
210604	Урсгал засвар	6,886,320.00	19,332,484.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,980,942.72	14,266,362.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,615,900.00	5,759,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,311,777.00	2,300,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,532.00	156,332.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,956.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		112,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,796,777.72	3,878,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,076,845.64	70,258,637.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн	4,758,000.00	200,000.00

	дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл,хорогдол	45,318,845.64	70,058,637.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,086,849.62	37,081,884.34
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,086,849.62	37,081,884.34
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,086,849.62	37,081,884.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	56,711,846.23	348,733,329.03
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	362,106.56	1,840,465.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	362,106.56	1,840,465.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(362,106.56)	(1,840,465.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	56,349,739.67	346,892,864.03

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,310,425,400.00	1,639,539,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,310,425,400.00	1,639,539,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,310,425,400.00	1,542,439,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,300,425,400.00	1,542,439,100.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	10,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	97,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		97,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,310,446,000.00	1,639,539,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,310,446,000.00	1,530,839,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,293,359,150.38	1,602,457,215.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,100,301,695.81	1,252,714,700.04
210101	Үндсэн цалин	531,046,282.25	743,711,476.80
210102	Нэмэгдэл	403,100,013.56	325,658,831.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,655,400.00	40,346,592.36
210104	Урамшуулал	125,500,000.00	142,997,799.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,963,600.00	160,441,091.35
210201	Тэтгэврийн даатгал	101,452,700.00	118,890,139.60
210202	Тэтгэмжийн даатгал	8,877,700.00	10,530,810.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,102,200.00	8,272,591.04
210204	Ажилгүйдлийн даатгал	1,775,500.00	2,066,222.77
210205	Эрүүл мэндийн даатгал	17,755,500.00	20,681,327.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,312,097.50	14,373,166.73
210301	Гэрэл, цахилгаан	912,097.50	1,173,166.73
210304	Байрны түрээс	14,400,000.00	13,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,703,095.49	24,451,611.54
210401	Бичиг хэрэг	4,892,100.00	6,329,530.00
210402	Тээвэр, шатахуун	6,222,500.00	7,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	220,184.49	1,067,081.54
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	368,311.00	9,800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,790,115.00	28,231,084.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,198,295.00	4,159,500.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	990,000.00	5,847,500.00
210604	Урсгал засвар	8,601,820.00	18,224,084.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,530,546.58	13,345,562.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,365,900.00	5,759,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,426,200.00	2,300,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,532.00	156,332.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	105,956.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	112,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,231,958.58	2,957,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,758,000.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,758,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,086,849.62	37,081,884.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,086,849.62	37,081,884.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,086,849.62	37,081,884.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(20,600.00)	108,700,000.00-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	108,700,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	108,700,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	108,700,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(20,600.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,600.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,349,638.94	398.00	114,033,297.11	378,383,334.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,349,638.94	398.00	114,033,297.11	378,383,334.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		0.00		0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн				0.00

2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,349,638.94	398.00	114,033,297.11	378,383,334.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	264,349,638.94	398.00	114,033,297.11	378,383,334.05
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			346,892,864.03	346,892,864.03
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	264,349,638.94	398.00	460,926,161.14	725,276,198.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
УРСГАЛ ЗАРДАЛ	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,266,057,000.00	1,252,714,700.04	13,332,299.96	98.9
Үндсэн цалин	754,315,200.00	743,711,476.80	10,603,723.20	98.6
Нэмэгдэл	328,076,400.00	325,658,831.18	2,417,568.82	99.3
Унаа хоолны хөнгөлөлт	40,665,400.00	40,346,592.36	308,807.64	99.2
Урамшуулал	143,000,000.00	142,997,799.70	2,200.30	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,826,400.00	160,441,091.35	8,385,308.65	95.0
Тэтгэврийн даатгал	126,544,500.00	118,890,139.60	7,654,360.40	94.0
Тэтгэмжийн даатгал	10,570,500.00	10,530,810.26	39,689.74	99.6
ҮОМШӨ-ний даатгал	8,456,400.00	8,272,591.04	183,808.96	97.8
Ажилгүйдлийн даатгал	2,114,100.00	2,066,222.77	47,877.23	97.7
Эрүүл мэндийн даатгал	21,140,900.00	20,681,327.68	459,572.32	97.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,759,300.00	14,373,166.73	1,386,133.27	91.2
Гэрэл, цахилгаан	1,354,900.00	1,173,166.73	181,733.27	86.6
Байрны түрээс	14,404,400.00	13,200,000.00	1,204,400.00	91.6
Хангамж, бараа материалын зардал	28,338,700.00	24,451,611.54	3,887,088.46	86.3
Бичиг хэрэг	7,356,100.00	6,329,530.00	1,026,570.00	86.0
Тээвэр, шатахуун	8,675,200.00	7,255,000.00	1,420,200.00	83.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,177,000.00	1,067,081.54	1,109,918.46	49.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	330,400.00	0.00	330,400.00	0.0

Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,800,000.00	9,800,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	46,557,900.00	39,831,084.00	6,726,816.00	85.6
Багаж, техник, хэрэгсэл	17,374,000.00	15,759,500.00	1,614,500.00	90.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,894,900.00	5,847,500.00	47,400.00	99.2
Урсгал засвар	23,289,000.00	18,224,084.00	5,064,916.00	78.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,515,100.00	13,345,562.00	3,169,538.00	80.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,414,400.00	5,759,700.00	1,654,700.00	77.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,590,200.00	2,000,000.00	590,200.00	77.2
Даатгалын үйлчилгээ	2,426,200.00	2,300,130.00	126,070.00	94.8
Тээврийн хэрэгслийн татвар	163,600.00	156,332.00	7,268.00	95.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	180,000.00	60,000.00	120,000.00	33.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,200.00	112,200.00	138,000.00	44.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,490,500.00	2,957,200.00	533,300.00	84.7
Бараа үйлчилгээний бусад зардал	394,700.00	200,000.00	194,700.00	50.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	394,700.00	200,000.00	194,700.00	50.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
Улсын төсвөөс санхүүжих	1,542,439,100.00	1,505,357,215.66	37,081,884.34	97.6
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49	76	(27.00)	155.1
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	42	69	(27.00)	164.3
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	-	100

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	97,100,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	97,100,000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		97,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	97,100,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	97,100,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		97,100,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг газрын дарга Б.Даваасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, тайлагналтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд “Б энд С аудит” ХХК-ийн аудитын 2 дугаар баг хариуцаж хэрэгжүүлэв.

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг тус аудитын компанид 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Гаалийн байгууллагын стратеги, зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх ;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх.

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газар нь 2007 онд үүсэн байгуулагдсан, улсын хилээр нэвтэрч буй шуудан илгээмжид гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт хийх /код 9412/ үндсэн үйл ажиллагаа явуулахдаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх зарчмыг баримтлан, Гаалийн тухай, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хуулиуд, Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай Олон улсын конвенци болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/323 дугаар тушаалаар Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог захиргаа, удирдлага 8, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн алба 25, гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх алба 5, гаалийн эрсдэлийн удирдлагын алба 4, санхүү, аж ахуйн алба 7 нийт 49 орон тоотой, төрийн тусгай 42, төрийн үйлчилгээний 7 ажилтан ажиллахаар баталсан байна.

Тайлант хугацаанд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 21, 167 дугаар тогтоолууд, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 167 дугаар тогтоол зэрэг коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын улмаас хууль тогтоомжид орсон өөрчлөлт болон цар тахлын тархалт, өвчлөлтэй холбоотой үүссэн нөхцөл байдлууд нь тус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлсөн байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/272 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байгаач шинэчлэн боловсруулж мөрдөж ажиллах шаардлагатай байна. .

Улс хоорондын Гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд Гаалийн ерөнхий газраас санхүүгийн тайлан, мэдээ болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс цахимаар хяналт тавьж ажилласан байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтыг “сайжруулах шаардлагатай” гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайланг үндэслэн үйл ажиллагааны нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайланг үндэслэн үйл ажиллагааны нийт зардал 1,594,745.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,947.4 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 346,892.8 мянган төгрөгөөр буюу 91.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,432.9	0	-2,432.9
Бараа материал	25,291.3	40,617.2	15,325.9
Үндсэн хөрөнгө	350,659.2	684,659.0	333,999.8
Нийт хөрөнгө	378,383.4	725,276.2	346,892.8
Засгийн газрын оруулсан капитал	264,349.6	264,349.6	0
Тайлант үеийн үр дүн	56,349.8	346,892.8	346,892.8
Хуримтлагдсан үр дүн	57,684.0	114,033.8	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	378,383.4	725,276.2	346,892.8

Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Авлагын данс нь 2020 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэлгүй байна. Өнгөрсөн оны авлагын үлдэгдэл хүн амын орлогын албан татвар 2,192.3 мянган төгрөг, ажилчидтай холбоотой 240.6 мянган төгрөг нийт 2,432.9 мянган төгрөгийг тайлант хугацаанд барагдуулжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 40,617.2 мянган төгрөг болж, 15,325.9 мянган төгрөгөөр өссөн нь ариутгал халдваргүйжилт, тусгай хэрэгслийн материал худалдан авсан, үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн зэргээс шалтгаалжээ.

Бараа материалын дансанд 2020 онд төсвийн хөрөнгөөр 39,057.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 6,741.0 мянган төгрөг нийт 45,798.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч тайлант хугацаанд байгууллагын дотоод хэрэгцээнд 30,472.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,063,961.8 мянган төгрөг болж 408,436.9 мянган төгрөгөөр өссөн нь Гаалийн ерөнхий газраас тайлант хугацаанд 299,736.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан, урсгал төсвийн санхүүжилтээр 11,600.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 97,100.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс шийдвэрлэсэн 97,100.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, хар тамхи илрүүлэх төхөөрөмж худалдаж авсан байна. Нууцын зэрэглэлд хамааралтай учир тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагааг Гаалийн ерөнхий газар зохион байгуулсан байна.

Уг төхөөрөмжийг Гаалийн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар орлого авсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 562 дугаар тогтоолыг үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны А/219 дугаар тушаалаар Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын үндсэн хөрөнгийн данснаас 64 нэр төрлийн 28,467.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устган, данс бүртгэлээс хассан байна.

Гаалийн шинэчлэлийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн гаалийн хяналт шалгалтын телехяналтын нэгдсэн системийн иж бүрдэл бүхий 18 төрлийн 193,500.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжөөс системийн камерын холболт, нэгдсэн удирдлагын 2 төрлийн 32,756.0 мянган төгрөгийн өртөгтэй лицензийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэлд 725,276.2 мянган төгрөг болж 346,892.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь гаалийн шинэчлэлтэй холбоотой хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна. Урт болон богино хугацаат өр төлбөр үлдэгдэлгүй байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 527,896.2 мянган төгрөгөөр буюу 37.3 хувиар өссөн.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь нэмэлт санхүүжилт 97,100.0 мянган төгрөг, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 242,013.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 200,184.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 237,715.1 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн байна. Өмнөх оноос нийт нэмэгдсэн зардлын 92 хувь нь цалин хөлс, нийгмийн даатгал, бараа,

үйлчилгээний бусад болон эд хогшил, урсгал засварын зардал байна. Энэ нь орон тоо нэмэгдүүлж ажилласнаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,879,162.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 336,726.3 мянган төгрөгөөр бууруулж, 1,542,439.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардлыг 314,338.8 мянга, байр ашиглалттай холбоотой зардал 3,734.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 13,585.3 мянга, хангамж, бараа материалын зардал 20,974.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,700.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил худалдан авах зардлыг 17,610.6 мянган төгрөгөөр тус тус хорогдуулсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,542,439.1 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,542,439.1 мянган төгрөг, урсгал үйл ажиллагаанд 1,505,357.2 мянган төгрөгийг зарцуулж, 37,081.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,505,357.2 мянган төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь тайлант хугацаанд цалин хөлс нэмэгдэл урамшуулал, шимтгэл 21,717.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 6,726.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,887.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 3,169.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,386.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 194.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төсвийн зардлын дутуу зарцуулалт нь төсвийн төлөвлөлт болон коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй эд хогшил, бараа материалын худалдан авалт, бусад ажил арга хэмжээ хязгаарлагдаж, урсгал засвар хийх боломж хомс, ашиглалтын зардал хэмнэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд татвар, хураамж, өөрийн орлогоор 31,091,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас шалтгаалан төлөвлөгөөг 11,900,000.0 мянган төгрөгөөр бууруулж 19,191,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр татвараас 20,255,900.0 мянга, хураамжаас 148,300.0 мянга, өөрийн орлогоос 328,700.0 мянга, нийт 20,733,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 108.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
1.Татвар	18,905,200.0	20,255,900.0	1,350,700.0	107.1
2.Хураамж	143,900.0	148,400.0	4,500.0	103.1
3.Өөрийн орлого	142,000.0	328,700.0	186,700.0	231.4
Нийт дүн	19,191,100.0	20,733,000.0	1,541,900.0	108.0

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс хар тамхи илрүүлэх төхөөрөмжийг 97,100.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтээр хүлээн авч тайлагнасан.

Нууцын зэрэглэлтэй шалтгаанаар тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагааг Гаалийн ерөнхий газраас зохион байгуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байршуулбал зохих 148 мэдээллээс 134 хугацаандаа, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 13 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газар нь “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэх журам”-ын шаардлага хангаж, сүүлийн 3 жилд “Зөрчилгүй” үнэлэгдэж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 2019 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, “Итгэмжлэл” авсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 407,350.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 399,539.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7811.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 399,539.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг үзэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 3, 5,10 дугаар сарын 399,539.6 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу мэдээлсэн, орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрд шийдвэрийн хуулбарыг хавсаргаагүй, дараа жилийн төсвийн төсөл болон аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хэсэгт “PDF” файлаар

байршуулсан мэдээлэл нээгдэх боломжгүй, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл хэсэгт мэдэгдэл байршуулаагүй, байгууллагын батлагдсан төсөв хэсэгт хоосон маягт байршуулсан, бонд, өрийн бичгийн баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт засвар хийлгэсэн гэрээ 4, хөрөнгө орлого авсан 5, хөрөнгө акталж устгасан 1 тушаалыг байршуулаагүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг хугацаа хоцорч мэдээлсэн зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.7."байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр "Журам шинэчлэн батлах тухай" тогтоолын 3.2.10 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар", 3.2.17 "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн сарын тайланг энэ журмын 23 дугаар зүйлийн хавсралтад заасан маягтын дагуу дараа сарын 8-ны дотор цахимаар"3.2.11 "зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар" зэрэг заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын улсын орлогод авсан барааны анхан шатны нэгж дээрх бүртгэл хөтлөлт хангалтгүй байгаа нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

- 1.1 Илрүүлэлт: Албан хаагчдын цалингаас суутгадаг хүн амын орлогын албан татварын тооцооллыг зөрүүтэй тооцоолж 14 албан хаагчаас 76.0 мянган төгрөг илүү, 33 албан хаагчаас олгох 484.0 мянган төгрөгийг дутуу, мөн унааны мөнгө 22 албан хаагчаас 53.5 мянган төгрөг илүү, хоолны мөнгө 312.0 мянган төгрөг дутуу нийт 925.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.7 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.
- 1.2 Эрсдэл: Татвар санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх; ажилчин албан хаагчдын цалин хөлс буруу тооцоологдох, төсвийг үр ашиггүй зарцуулах
- 1.3 Өгсөн зөвлөмж: Ажилчин, албан хаагчдын цалингаас суутгах хувь хүний албан татварын тооцооллыг үнэн зөв хийх.
- 1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал:

- 2.1 Илрүүлэлт: Бараа материалын дансанд 6,391.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн, 494.5 мянган төгрөгийн бараа материалыг буруу ангилан данс хооронд зөрүүтэй бүртгэсэн. Энэ нь УСНББОУС 12, 17, Сангийн сайдын 2008 оны "Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" /2006 оны 388-д/ 352 дугаар тушаалыг зөрчиж байна.
- 2.2 Эрсдэл: Хяналт суларч, хөрөнгө дутагдах, хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй зарцуулах, биетээр оршихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- 2.3 Өгсөн зөвлөмж: УСНББОУС 12, 17-д зааснаар бараа материал болон үндсэн хөрөнгийг үнэн зөв бүртгэх, бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлж, залруулж бүртгэх;
- 2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тус хөрөнгүүдийг 2021 онд залруулж бүртгэнэ.

3. Балансын данстай холбоотой асуудал:

- 3.1 Илрүүлэлт: Төсөв, гүйцэтгэлийн тайлангүй, гэрээ дүгнээгүй, харьцуулсан үнийн судалгаагүй хөрөнгө худалдан авч, засвар үйлчилгээ хийсэн байна.
- 3.2 Эрсдэл: Хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;
- 3.3 Өгсөн зөвлөмж: Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж данс дүргэлд тусгахгүй байх, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллах;
- 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

4. Бүтэц орон тоотой холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/323 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоог 49-р баталсан боловч тайлант жилд 27 орон тоо нэмэгдүүлж ажиллуулсан байна.

4.2 Эрсдэл: Төсвийн төлөвлөлт алдагдах

4.3 Өгсөн зөвлөмж: Бүтэц орон тооны хязгаарыг баримталж ажиллах, шаардлагатай орон тоог дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2020/34/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Батлагдсан орон тооноос албан хаагч илүү ажиллуулж, цалин олгосон.	-	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Даваасүрэн Б.Ганбат
2	Хүн амын орлогын албан татвар болон унаа, хоолны мөнгийг зөрүүтэй тооцоолсон.	925.5	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ахлах нягтлан бодогч	
3	Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	6,391.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ахлах нягтлан бодогч	
4	Бараа материалын данс хооронд зөрүүтэй бүртгэсэн.	494.5	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ахлах нягтлан бодогч	
5	Засвар үйлчилгээ хийхдээ төсөв байхгүй, гэрээ дүгнээгүй, харьцуулсан үнийн судалгаа хийгээгүй гүйлгээг анхаарах	-	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ахлах нягтлан бодогч	
6	Тайлант хугацаанд байршуулбал зохих 148 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 13 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	399,539.6	Албан шаардлага	Дарга, Ахлах нягтлан бодогч	
	Дүн	407,350.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 229/АД170070.

САТ-2021/34/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 1,542,439.1 мянган төгрөгийн 148 мэдээлэл байршуулахаас 399,539.6 мянган төгрөгийн 13 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, мөн 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.




Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж мэдээллийн ил тод байдлыг ханган, тогтоосон хугацаанд тогтмол байршуулах, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Б.Даваасүрэн, ахлах нягтлан бодогч Б.Ганбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:
"Б ЭНД С АУДИТ" ХХК-ИЙ ЗАХИРАЛ




Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРЖАВ
Д.ДАШХОРЛОО

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 26 rows.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

